

***Салхинцэцэг өвчний
тархвар судлал, өвчлөлийн
байдал, голомтонд
авах арга хэмжээ***

***ХӨСҮТ, ТҮН
2017.3.15 он***

Тодорхойлолт:

- *Херпесийн бүлгийн вирусээр үүсгэгддэг, арьсан дээр цэврүүт тууралтаар илэрдэг түгээмэл халдварт өвчин юм.*
- *Салхинцэцэг нь хүүхдэд зонхилон тохиолддог, хөнгөн явцтай ч нийгмийн эрүүл мэндийн чухал асуудал хэвээр байна.*

Өвчин үүсгэгч:

- *Херпесийн бүлгийн (varicella zoster) вирус*
- *150-200 нм хэмжээтэй*
- *Иксоэдр хэлбэртэй*
- *ДНХ-ийн хос ороомгийг агуулсан*
- *Гадаад орчинд болон өндөр хэмийн дулаанд тэсвэргүй*
- *Эсийн дотор мөхлөг үүсгэн, өсөж үрждэг*
- *Зөвхөн хүнд өвчлөл үүсгэдэг*

Тархвар судлал

Халдварын эх уурхай нь: Салхинцэцэг өвчтэй, халдвар авсан хүн байна.

Халдвар дамжих зам нь:

- Шууд хавьтлаар:
- шууд бус зам:

Салхинцэцэгтэй өвчтөн ханиах, найтаахад өвчин үүсгэгч вирус бүхий бяцхан усан дусал агаарт тархана. уг вирусийг амьсгалтай хамт татаж авсан хүний уушигаар дамжин 2-3 долоо хоногийн дараа **шинж тэмдэгүүд илэрнэ.**

Тархвар судлал

- *Уушгаар орсон вирус нь цусаар дамжин арьс руу очиж тууралтыг үүсгэдэг. Тууралт бий болохоос өмнө олон хүн өөрсдийгөө салхинцэцгээр өвчилсөнөө мэдээгүй ч халдвартай болсон байдаг. Энэ нь уг өвчинийг маш хурдан тархдаг гол шалтгаан юм.*
- **Халдвартай үе:** *тууралт гарахаас 1–2 хоногийн өмнө болон хамгийн сүүлийн цэврүүт тууралт хатах хүртэл халдвартай байна. Дархлалын өөрчлөлттэй өвчтөнд халдвартай үе илүү урт байна.*
- **Нууц үеийн үргэлжлэх хугацаа**
Нууц үеийн хугацаа 14-21 хоног. Дунджаар 14-16 хоног.


Өртөмтгий буюу мэдрэг хүн ам

- *Халдвар аваагүй хүмүүсийн дунд салхинцэцгийн халдвар авах магадлал өндөр.*
- *Халдварт өртөмтгий хүмүүс гэртээ халдвар авах нь 80–90%-ийн эрсдэлтэй.*
- *Эх нь дархлаа байхгүй нярай, лекейми оноштой өвчтөнүүд илүү хүндрэл ихтэй.*
- *Хорт хавдар, ялангуяа лимфийн эдийн хавдартай насанд хүрэгсэд, дархлааны хомсдолтой өвчтөнүүд болон дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж буй хүмүүс өртөмхий.*

Тархалт:

- *Дэлхий дахинд энэ халдвар нь маш түгээмэл. Сэрүүн бүсийн орнуудад хүн амын 90% нь 15 нас хүрэхээс өмнө, 95% нь насанд хүрэхээс өмнө халдвар авна.*
- *Эдгээр орнуудад өвчлөл өвөл ба хавар гардаг.*
- *Халуун орнуудад өвчлөлийн тархвар судлалын онцлог өөр байх ба насанд хүрэгчид өвчлөх нь түгээмэл.*

Манай улсад салхинцэцгийн өвчлөл 1952-2016 он




Манай улсад салхинцэцэг өвчнийг 1952 оноос албан ёсоор бүртгэж эхэлсэн. 1961 онд 10000 хүн ам тутмаас 48 хүн өвдөж байсан байна.

Салхинцэцэг өвчлөлийн байдал


Улсын хэмжээнд: 2016 онд 6,834 тохиолдол 10,000 хүн амд 22.3 тохиолдол бүртгэгдсэн нь нийт цочмог халдварт өвчний дотор 9.8%-ийг эзэлж, өмнөх оны мөн үе, сүүлийн 5 жилийн дунджаас 3.3-5.5 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2016 онд өвчлөл 10 дугаар сараас эхлэн нэмэгдэж, 12 дугаар сард оргил үедээ хүрчээ.

Улсын хэмжээнд 2016, 2015 он болон сүүлийн 5 жилд бүртгэгдсэн салхинцэцгийн өвчлөл, сараар




Улсын хэмжээнд 2015, 2016 онд бүртгэгдсэн салхинцэцгийн өвчлөл (аймаг, хотоор)




10,000 хүн амд ногдох өвчлөл: Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн салхинцэцгийн өвчлөлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад: ДУ, ЗА, ГС, СБ, ДА, ӨМ, ГА, ӨВ, БХ, ХӨ, ДГ, АХ, СЭ аймгууд болон Улаанбаатар хотод өвчлөл (10,000 хүн амд 0.1-33) –оор нэмэгдсэн байна.

ДО, СБ, ӨМ, ДГ, ДУ, ӨВ, ЗА, ДА аймгууд болон УБ хотод улсын дундаж түвшин (3.5%)–ээс дээгүүр үзүүлэлттэй байна.

УБ хотод 2016 онд бүртгэгдсэн салхин-цэцгийн өвчлөл (дүүргээр, 10,000 хүн амд)




Улаанбаатар хотод: 2016 онд бүртгэгдсэн (10000 хүн амд) өвчлөлийг өнгөрсөн оны мөн үе, сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад БЗ, БХ, ХУ, СХ, ЧД дүүргүүдэд (0.3-21.9) тус тус нэмэгдсэн байна. БЗД, ХУД, БНД-үүдэд нийслэлийн дундажаас (26.5) дээгүүр үзүүлэлттэй байна




Баянзүрх дүүрэг: УБ хотод 2016 онд бүртгэгдсэн нийт салхинцэцгийн өвчлөлийн 35.9% нь тус дүүрэгт гарсан ба өнгөрсөн оны мөн үеэс (10000 хүн амд) 9.9, сүүлийн 5 жилийн дунджаас 24.5, УБ-ын дундаж 20 дээгүүр үзүүлэлттэй байна.

2015, 2016 онд бүртгэгдсэн салхинцэцгийн өвчлөл (насаар)




Өвчлөгсдийн 76%(5200)-ийг 0-9 нас, үүний дотор 0-4 нас 54%(3700)-ийг эзэлж байна.

2015, 2016 онд бүртгэгдсэн салхинцэцгийн өвчлөл (нийгмийн байдлаар)



Нийгмийн байдлаар: Өвчлөгсдийн 41.6% нь цэцэрлэгийн хүүхэд, 23.9% нь гэрээр хүмүүждэг хүүхэд, 18.7% нь сургуулийн сурагчдын өвчлөл байна. (ХБ-65.5 %)

Өвчлөгсдийн эмнэлэгт хандсан хугацаа



- Салхинцэцгээр өвчлөгсдийн 98% нь халдвартай үедээ буюу тууралт эхлэхээс өмнөх 1-2 хоногт, тууралтын ид үедээ гэртээ байсан нь гэрээр халдвар тархах нөхцлийг бүрдүүлсэн байна.
- Мөн өвчлөгсдийн 85% нь халдвартай үедээ тусгаарлагдахгүй, гэрээр эмчлэгдэж байгаа нь халдвар дамжин тархах нөхцлийг бүрдүүлж байна.
- Өвчлөгсөдийн 38.5 нь өвчний шинж тэмдэг эхэлснээс хойш 2-19 хоногийн дараа эмчид хандаж үзүүлж байгаа нь салхинцэцэг өвчний талаар иргэдийн мэдлэг хангалтгүй, өвчин хүндэрсний дараа эмчид хандан, өвчний голомтонд авах арга хэмжээг оройтуулж, халдвар тархах нөхцлийг бүрдүүлж байна.

Хүүхдийн байгууллага

Улаанбаатар хотын хэмжээнд 2016 онд 551 хүүхдийн байгууллагад 1858 тохиолдол (сургуульд 27.7%, цэцэрлэгт 72.3%) бүртгэгдсэн нь байна.

Дүүргийн нэр	Сургуулийн тоо	Тохиолдлын тоо, %	Голомтын индекс	Цэцэрлэгийн тоо	Тохиолдлын тоо, %	Голомтын индекс
БГД	34	83 (16.1%)	2.4	55	200 (15%)	3.6
БЗД	59	191 (37.2%)	3.2	100	504 (37.5%)	5
СХД	29	66(12.8%)	2.3	62	207(15.4%)	3.3
СБД	35	80(15.5%)	2.3	49	150(11.1%)	3.1
ЧД	22	53(10.3%)	2.4	46	163(12.1%)	3.5
ХУД	22	41(7.9%)	1.9	38	120(9.1%)	3.2
Нийт	201	514 (100%)	2.6	350	1344 (100%)	3.8

Үүнээс БЗД-т 159 хүүхдийн байгууллагад 695 тох бүртгэгдсэн байна. БЗД-ийн өвчлөл 59 сургуульд 191 тох буюу голомтын индекс 3.2, 100 цэц-т 504 тох буюу голомтын индекс 5 байгаа нь бусад дүүрэгтэй харьцуулахад өндөр байна. Салхинцэцгийн өвчлөл ХУД-т хамгийн бага бүртгэгдсэн, нийт 60 хүүхдийн байгууллагаас 161 тох бүртгэгдсэн ба 22 сургуулийн 41 тох буюу голомтын индекс 1.9, 38 цэцэрлэгийн 120 тох буюу голомтын индекс 3.2 байна.

Дүгнэлт.

- Улсын хэмжээнд салхинцэцгийн өвчлөл, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Дундговь, Дорноговь, Өвөрхангай, Завхан, Дархан аймаг, нийслэлд улсын дунджаас өндөр байна.
- Нийт бүртгэгдсэн тохиолдлын дийлэнх нь хүүхдийн байгууллагад буюу **0-4 насны** хооронд байна
- Хүүхдийн байгууллагаас салхинцэцгээр өвчлөгсдийн **98%** нь халдвартай үедээ буюу тууралт эхлэхээс өмнө 1-2 хоног, тууралтын ид үед эмнэлэгт хандахгүй сургууль, цэцэрлэгтээ явж байсан байна. **Улаанбаатар хотын хэмжээнд 2016 онд 551 хүүхдийн байгууллагад 1,858 тохиолдол** (сургуульд 28%, цэцэрлэгт 72%) бүртгэгдэж, **голомтын индекс 3.2 байна.**
- Хүүхдийн байгууллагаас өвчлөгсдийн **96%** тууралт гарснаас 1-4 хоногийн дараа дараа эмчид үзүүлж, оношлогдсон.
- Хүүхдийн байгууллагаас өвчлөгсдийн **53.4%-ийг** бүрэн эдгэрээгүй байхад хичээлд нь авсан байна.

Эрүүл мэндийн болон хүүхдийн байгууллагуудад цаашид

Эрүүл мэндийн байгууллага:

- “Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалт, эмчилгээ, оношилгоо”-ны стандартыг мөрдөж ажиллах
- Хүн амын дунд салхинцэцэг өвчнөөс сэргийлэх сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх
- ӨЭМТ-үүд харъяа сургууль, цэцэрлэгт тандалт тогтмол хийж, мэдээллээ солилцон, хамтарч ажиллах

Хүүхдийн байгууллага:

- Халдварт өвчин гарсан голомтонд ЭМС-ын 2012 оны 216 тоот тушаалыг хэрэгжүүлж ажиллах
- Өвчилсөн хүүхдийг бүрэн эдгэрсний дараа хүлээн авах

Хариу арга хэмжээ

Мэдээлэл:

- Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд салхинцэцэг өвчний тохиолдол бүрийг бүртгэж харьяа ЭМТ, ХӨСҮТ-д мэдээлнэ. ЭМС-ын 2013 оны 450 тоот тушаалаар батлагдсан (ЭМБүртгэлийн маягт-2) мэдээлнэ.

Илрүүлэлт:

- Сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлэх, ялангуяа цэргийн хуаран, сургууль, цэцэрлэг, ясли, оюутны байр зэргийг идэвхтэй тандалтанд авна.

Тусгаарлалт

- Онош батлагдсан өвчтөнүүдийг өвчний явцаас хамаарч халдвартын эмнэлэг (тасаг)-т болон гэрээр эмчилнэ. Эмнэлэгт дархлаа султай хүмүүст халдвар тархахаас сэргийлэн халдвар хамгаалалын дэглэмийг чанд баримтална.
- Гэрээр эмчлэгдэж байгаа хүүхэд, насанд хүрэгсдийг хичээл, ажлаас чөлөөлж, бүрэн эдгэртэл өрхийн эмчийн хяналтанд байлгана.

Халдваргүйтгэл:

- Өвчтөний хамар, залгиурын шүүрлээр бохирлогдсон эд зүйлсийг халдваргүйтгэнэ.
- Эцсийн халдваргүйтгэл хийхгүй.

Хариу арга хэмжээ

Хөл хорио:

- *Тогтоохгүй.*
- *Гэвч эмнэлэгт халдварт өртөх эрсдэл өндөртэй хүүхдүүд, стеройд, дархлал дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнүүдэд хавьтал болсноос хойш 10 хоногоос доошгүй хугацаанд халдвар тархахаас сэргийлэх арга хэмжээ авна.*

Хавьтагсадад авах арга хэмжээ:

- *Өртөмхий бүлгийн хавьтагсадад 21 хоног өрхийн эмчийн ажиглалт тогтооно.*

Дэгдэлтээс сэргийлэх арга хэмжээ

- *Салхинцэцэг нь сургууль, цэцэрлэгийн байгууллагад дэгдэлт хэлбрээр гарах нь нийтлэг, хүндрэл өгдөг тул халдвартай тохиолдлыг тусгаарлаж, хавьтлыг ажиглана.*

Урьдчилан сэргийлэлт

Өвөрмөц сэргийлэлт:(Салхинцэцгийн хүчийг нь сулруулсан амьд вакциныг Япон, АНУ, Европийн зарим орнуудад)

Өвөрмөц бус сэргийлэлт:

- Агааржуулалт, чийгтэй цэвэрлэгээ*
- Улирлын байдалд тохируулан хувцаслах*
- Илчлэг сайтай тэжээллэг хоол хүнс хэрэглэх*
- Хоол хүнсээ халуунаар хэрэглэх*

*Та бүхний эрүүл энхийн
манаад амжилт хүсье*

БАЯРЛАЛАА